



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

# ОЛОН УЛСЫН ТӨЛБӨР ТООЦООНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

---

2022.06.22

Монголбанк, Төлбөр тооцооны газар, Бодлого зохицуулалт,  
үйл ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Уясах



Олон улсын санхүүгийн байгууллага хооронд гүйлгээний цахим мэдээ дамжуулах нийгэмлэг (Society for Worldwide Interbank Financial Telecommunication - SWIFT СВИФТ) нь 1973 онд байгуулагдсан Бельги улсад төвтэй санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээ дамжуулах сүлжээ байгууллага юм.



# Банк, санхүүгийн салбарт тавигдаж байсан хориг арга хэмжээ (2014 он)



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



ОХУ нь 2014 онд Украины Крым хотыг эзлэн авсан. Энэ үед Атлантын далайн хоёр эргийн холбоотнууд ОХУ-ын банкуудыг SWIFT сүлжээгээр төлбөр тооцоо гүйцэтгэхэд хориг арга хэмжээ авах талаар яригдаж байсан ч ямар нэгэн хориг тавигдаагүй.



Манай улсын хувьд ОХУ-тай SWIFT сүлжээгээр дамжуулдаг төлбөр тооцоо хэвийн дамжиж байсан.



Мастер карт, Виза карт интернэшнл байгууллага ОХУ-ын төлбөрийн картын гүйлгээг хийхээс тухайн үедээ татгалзсан.

# Банк, санхүүгийн салбарт тавигдсан хориг арга хэмжээ (2022 он)



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

SWIFT-ээс **ОХУ-ын 8 банк**  
тэдгээрийн салбарыг хассан  
(EU Council Regulation (EU)  
2022/345):

1. BANK OTKRITE
2. NOVIMBANK
3. PROMSVYAZBANK
4. BANK ROSSIYA
5. SOVCOMBANK
6. VNESHECONOMBAN (VEB)
7. VTB BANK
8. MKB (2022.06.14)

ОХУ-ын SWIFT-ээс хасагдаагүй банкууд  
руу рубль, юань гэх мэт хориг арга  
хэмжээнд ороогүй гадаад **валютаар**  
**төлбөр тооцоо хийх**

Манай банкууд SWIFT-ийн гүйлгээг  
дамжуулдаг олон улсын дундын банкууд  
**хориг арга хэмжээний хүрээнд төлбөр**  
**тооцоог хязгаарлалтайгаар дамжуулж**  
**байна.**

SWIFT-ээс **БНБУ-ын 3 банк**  
тэдгээрийн салбарыг хассан  
(EU Council Regulation (EU)  
2022/398):

1. BELAGROPROMBANK
2. BANK DABRABYT
3. DEVELOPMENT BANK  
OF THE REPUBLIC OF  
BELARUS

Хасагдсан банкууд руу **ямар нэгэн гүйлгээ дамжуулах**  
**боломжгүй.**



# ОХУ-тай хоёр талын шилжүүлэг, Банкуудын ОХУ дахь ностро дансны үлдэгдэл



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

сая ам.доллараар /2021 он/

Валют төрөл	ОХУ-ТАЙ ХОЁР ТАЛЫН ШИЛЖҮҮЛЭГ				Цэвэр дүн
	ОХУ-аас		ОХУ руу		
	Дүн	Эзлэх жин	Дүн	Эзлэх жин	
USD	367.2	86.6%	1,027.8	65.8%	(660.7)
<b>RUB</b>	<b>42.2</b>	<b>10.0%</b>	<b>476.0</b>	<b>30.5%</b>	<b>(433.8)</b>
EUR	13.0	3.1%	57.7	3.7%	(44.8)
CNY	0.1	0.0%	1.1	0.1%	(1.0)
Бусад	1.5	0.3%	0.3	0.0%	1.1
<b>Нийт</b>	<b>424.0</b>	<b>100.0%</b>	<b>1,563.1</b>	<b>100.0%</b>	<b>(1,139.1)</b>



# ОХУ руу хийгдсэн гадаад гүйлгээ, 2022.02.24 – 2022.06.10-ны өдрийн хороонд



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

сая ам.доллараар

	7 хоногоор															Сүүлийн өдрүүд					Нийт	Эзлэх жин	Сүүлийн 7 хоног дундаж	
	2/24- 2/25	2/28- 3/04	3/07- 3/11	3/14- 3/18	3/21- 3/25	3/28- 4/01	4/04- 4/08	4/11- 4/15	4/18- 4/22	4/25- 4/29	5/01- 5/07	5/09- 5/13	5/16- 5/20	5/23- 5/27	5/30- 6/03	6/06- 6/10	6/06	6/07	6/08	6/09				6/10
<b>Нийт</b>	37.0	24.0	106.8	18.8	38.8	23.8	66.3	20.8	15.6	8.5	64.1	40.5	75.8	27.0	46.7	16.3	1.6	0.2	9.8	2.7	2.0	<b>630.8</b>	<b>100%</b>	<b>3.25</b>
<b>Гүйлгээний зориулалтаар</b>																								
Шатахуун, тосолгооны материал	26.2	10.8	88.5	5.0	21.2	11.7	57.9	9.9	2.3	0.9	51.3	35.4	71.1	21.7	37.1	1.0	0.0	0.0	0.0	0.9	0.0	451.9	71.6%	0.20
Хүнс, өргөн хэрэглээний бараа	3.8	5.8	6.7	5.4	9.0	3.7	4.3	4.7	5.9	3.6	0.7	1.3	2.0	2.0	2.9	3.4	1.1	0.0	0.5	0.8	1.0	65.1	10.3%	0.68
Барилгын материал	3.0	1.3	2.8	2.7	1.9	0.8	1.0	1.1	1.3	0.4	0.2	0.2	0.7	0.7	0.5	1.2	0.0	0.1	0.2	0.9	0.0	20.0	3.2%	0.25
Үйлчилгээ	1.0	0.9	3.0	1.4	3.4	1.3	0.5	3.8	0.4	0.5	1.0	0.8	0.9	0.5	3.6	0.7	0.4	0.0	0.2	0.1	0.0	23.9	3.8%	0.15
Машин механик, тоног төхөөрөмж	0.7	4.0	2.4	0.9	1.9	1.4	1.6	0.2	0.8	1.1	0.1	1.8	0.1	0.5	0.1	0.7	0.0	0.0	0.6	0.0	0.0	18.5	2.9%	0.14
Аж үйлдвэрлэлийн орц	0.5	0.8	0.9	1.1	0.9	4.4	0.5	0.8	2.0	0.1	2.9	0.0	0.2	1.4	2.1	0.3	0.1	0.0	0.2	0.0	0.0	19.1	3.0%	0.05
Бусад	1.5	0.4	2.4	2.2	0.5	0.4	0.4	0.2	2.8	1.8	7.8	1.0	0.8	0.2	0.4	9.0	0.0	0.0	8.0	0.0	0.9	31.8	5.0%	1.79
Буцсан гүйлгээ	0.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.6	0.1%	0.00
<b>Валютын төрлөөр</b>																								
USD	29.7	13.0	95.7	12.2	30.5	14.5	61.8	17.2	7.6	5.2	52.6	36.5	71.1	22.0	41.7	9.4	0.4	0.0	8.0	0.0	0.9	520.5	82.5%	1.88
RUB	6.9	10.6	10.8	5.8	7.4	6.6	3.7	2.9	5.9	3.1	11.4	2.1	3.2	3.1	3.4	2.5	0.2	0.0	0.7	0.7	0.9	89.4	14.2%	0.51
CNY	0.0	0.0	0.0	0.4	0.4	2.3	0.3	0.5	2.1	0.2	0.1	1.9	1.5	2.0	1.6	3.7	1.0	0.1	0.4	2.0	0.1	16.9	2.7%	0.74
EUR	0.4	0.5	0.4	0.4	0.4	0.4	0.5	0.2	0.1	0.0	0.0	0.0	0.1	0.0	0.0	0.6	0.0	0.0	0.6	0.0	0.0	4.0	0.6%	0.13
<b>Нийт</b>	<b>37.0</b>	<b>24.0</b>	<b>106.8</b>	<b>18.8</b>	<b>38.8</b>	<b>23.8</b>	<b>66.3</b>	<b>20.8</b>	<b>15.6</b>	<b>8.5</b>	<b>64.1</b>	<b>40.5</b>	<b>75.8</b>	<b>27.0</b>	<b>46.7</b>	<b>16.3</b>	<b>1.6</b>	<b>0.2</b>	<b>9.8</b>	<b>2.7</b>	<b>2.0</b>	<b>630.8</b>	<b>100%</b>	<b>3.25</b>



## АНУ-ын Ерөнхий лиценз (General licenses)

Хориг арга хэмжээнүүд нь зөвхөн зорилтот бүлэгт нөлөөлж, гуравдагч этгээдэд ямар нэг хүсээгүй үр дагавар үзүүлэхээс сэргийлэн АНУ-ын Засгийн газраас **8 төрлийн ерөнхий лиценз** гаргаж, дараах зориулалтын төлбөр тооцоог АНУ-ын бус, хориг арга хэмжээнд ороогүй байгууллагаар дамжуулан гүйцэтгэхийг зөвшөөрсөн. Үүнд:

- Цар тахалтай холбоотой хөдөө аж ахуйн болон эрүүл мэндийн бараа бүтээгдэхүүнүүд,
- **Эрчим хүч, нефтийн бүтээгдэхүүн,**
- Тодорхой өр, хувьцааны зарим арилжаа,
- Дериватив гэрээ зэрэг.



DEPARTMENT OF THE TREASURY  
WASHINGTON, D.C.

OFFICE OF FOREIGN ASSETS CONTROL

Executive Order 14024 of April 15, 2021  
Blocking Property With Respect To Specified Harmful Foreign Activities of the  
Government of the Russian Federation

GENERAL LICENSE NO. 8

Authorizing Transactions Related to Energy

(a) Except as provided in paragraph (c) of this general license, all transactions prohibited by Executive Order (E.O.) 14024 involving one or more of the following entities that are related to energy are authorized, through 12:01 a.m. eastern daylight time, June 24, 2022:

(1) State Corporation Bank for Development and Foreign Economic Affairs  
Vnesheconombank;

(2) Public Joint Stock Company Bank Financial Corporation Otkritie;

(3) Sovcombank Open Joint Stock Company;

(4) Public Joint Stock Company Sberbank of Russia;

(5) VTB Bank Public Joint Stock Company; or

(6) Any entity in which one or more of the above persons own, directly or indirectly, individually or in the aggregate, a 50 percent or greater interest.

(b) For the purposes of this general license, the term “related to energy” means the extraction, production, refinement, liquefaction, gasification, regasification, conversion, enrichment, fabrication, transport, or purchase of petroleum, including crude oil, lease condensates, unfinished oils, natural gas liquids, petroleum products, natural gas, or other products capable of producing energy, such as coal, wood, or agricultural products used to manufacture biofuels, or uranium in any form, as well as the development, production, generation, transmission, or exchange of power, through any means, including nuclear, thermal, and renewable energy sources.

## CIPS систем

“Олон улсын банк хоорондын төлбөр тооцооны систем” (Cross border interbank payment system - CIPS) нь Хятадын Ардын банкны дэмжлэгтэйгээр **2015 онд нэвтрүүлсэн** улс хоорондын гадаад гүйлгээний систем юм.

CIPS систем нь бүх гүйлгээ, түүний төлбөр тооцоо (settlement)-г **юаниар гүйцэтгэдэг.**

Тус системээр 2021 оны байдлаар **80 орчим триллион юань (12.68 триллион ам.доллар)**-ийн гүйлгээ дамжсан байна

Нийт 1,288 оролцогчтой:

-76 шууд оролцогч

-1,212 шууд бус оролцогч

-дэлхийн 104 улстай хамтран ажилладаг.

## SPFS систем

ОХУ-ын Төв банкаас SPFS буюу “Санхүүгийн мессэж дамжуулах систем”-ийг **2014 оноос эхэлж хөгжүүлж эхэлсэн.**

“Олон улсын санхүүгийн байгууллага хоорондын цахим мэдээ солилцох (ISO20022) стандарт”-ын дагуу гүйлгээ дамжуулдаг бөгөөд **24/7/365 горимоор гүйлгээгээ илгээж, хүлээн авдаг.**

SPFS систем нь одоогийн байдлаар дотоод, гадаадын **400 гаруй банк, санхүүгийн байгууллага** гишүүнээр элссэн.



# СПФС (SPFS) системийн давуу болон сул тал



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

## Давуу тал:

ОХУ-ын Засгийн газраас БНТУ, Исламын Бүгд Найрамдах Иран Улс зэрэг хөгжиж буй орнуудыг системдээ нэгтгэхээр яригдаж байгаа;

Манай банкууд зөвхөн ОХУ-тай холбоотой **рублийн гүйлгээгээ дамжуулах боломжтой гарц.**

## Сул тал:

Гүйлгээний шимтгэл нэгж гүйлгээ бүрээс 0.80–1.00 ₮ (0.014–0.018 ам.доллар);

ОХУ-ын дотоодын гүйлгээ голдуу дамждаг;

Манай улсын банкуудаас тус системд холбогдож, гүйлгээ дамжуулдаг банк одоогоор байхгүй.

## Давуу тал:

БНХАУ болон олон улсын банк, санхүүгийн байгууллага холбогдсон **өргөн сүлжээ**;

Шууд бус оролцогчид тавигдах шаардлага, шалгуур харьцангуй бага тул **холбогдоход хялбар**;

Худалдаа хөгжлийн банк, Ариг банк, Төрийн банк нь тус системийн **шууд бус оролцогч**.

## Сул тал:

Шууд бус оролцогчоор SWIFT сүлжээг ашиглах холбогдох боломжтой тул тус сүлжээнээс тухайн банк хасагдсан тохиолдолд CIPS-ийг ашиглах боломжгүй болно;

Бүх гүйлгээ, төлбөр тооцоог **юань-р гүйцэтгэдэг**.

# Монголбанкаас хэрэгжүүлсэн арга хэмжээний хураангуй



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

**2022.02.27**

•ОХУ, Украин улсын хооронд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан дэлхийн улс орнуудаас ОХУ-ын эсрэг тавьсан санхүүгийн хориг арга хэмжээ болон үүсэж буй нөхцөл байдлын талаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулсан.

**2022.03.01**

•ОХУ-ын зарим банкуудыг СВИФТ сүлжээнээс хасах талаар шийдвэр гарсантай холбогдуулан Монголын банкны холбооны дэргэдэх Төлбөр тооцооны мэргэжлийн зөвлөлтэй хамтран цахим уулзалт зохион байгуулж, ОХУ-ын банкуудаар дамжиж хийгддэг төлбөр тооцоо, нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцож, авах арга хэмжээний талаар хэлэлцсэн.

**2022.03.02-одоог**

•Нөхцөл байдал хүндэрч, хориг арга хэмжээнээс шалтгаалан ОХУ-тай хийх төлбөр тооцоо саатах эрсдэл бий болсон тул нийт банкуудтай холбогдож, ОХУ-тай төлбөр тооцоо хэрхэн гүйцэтгэж байгаа, ямар хүндрэл үүссэн талаар долоо хоног бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр мэдээлэл авч, нэгтгэн ажиллаж байна.

**2022.03.04**

•ОХУ-аас худалдан авах газрын тосны бүтээгдэхүүний төлбөр тооцоог хэрхэн гүйцэтгэх боломжтой байгаа талаар УУХҮЯ-нд зөвлөмж хүргүүлсэн.

**2022.03.15 2022.04.13**

•Банкны салбар, гадаад дотоод төлбөр тооцооны нөхцөл байдал, үүсэж болзошгүй эрсдэл, авах арга хэмжээний төлөвлөгөөний талаар ЗГ-ын ээлжит хуралдаанаар танилцуулсан

**2022.03.22**

•ОХУ-ын Төв банкнаас СПФС төлбөрийн системд холбогдоход шаардагдах хугацаа, тавигдах шаардлага, гүйлгээний хураамж шимтгэлийн талаар судалгаа авсан.

**2022.03.29**

•ОХУ-ын Төв банктэй хэрхэн хамтран ажиллах, СПФС системд холбогдсоноор бий болох эрсдэлийн талаар зөвлөмж авах талаар Гадаад харилцааны яаманд албан бичиг хүргүүлсэн.

# Монголбанкаас хэрэгжүүлсэн арга хэмжээний хураангуй



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

**2022.04.29**

• АНУ-ын Сангийн яамны дэргэдэх Гадаад хөрөнгийн хяналтын газар (OFAC)-аас ОХУ-ын банкуудад тавьсан хориг арга хэмжээ нь ОХУ-аас манай улс руу импортлох нэн шаардлагатай бараа, бүтээгдэхүүний төлбөр төлөхөд хүндрэл учруулж байгаа болон шаардлагатай арга хэмжээ хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг албан захилдлаар тус байгууллагад хүргүүлсэн.

**2022.05.16 2022.05.19**

Монголбанкны албан захидалд АНУ-ын Гадаад хөрөнгийн хяналтын газар (OFAC)-аас тус байгууллагаас тавьж байгаа хориг арга хэмжээ нь зөвхөн ОХУ болон АНУ-ын хооронд хамааралтай бөгөөд АНУ-ын хуулийн этгээдээр мөрдүүлэх зорилготой, эдгээр хориг арга хэмжээ нь МУ, тэдгээрийн банк, санхүүгийн байгууллагуудад ямар нэгэн нөлөө байхгүй тухай хариу ирүүлсэн. Мөн бүх банканд энэ талаар мэдэгдсэн.

**2022.06.03**

• Нөхцөл байдалтай холбогдуулан Европын холбооны (EU) 2022/879 дугаар шийдвэр гарч олон улсын төлбөр тооцооны СВИФТ сүлжээнээс ОХУ-ын Сбер банк (Sberbank), Москва Кредит банк (Credit bank of Moscow), Хөдөө Аж Ахуйн банк (Rosselkhozbank)-уудыг 6 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хассан.

**2022.06.10**

• ОХУ-ын нөхцөл байдал хүндэрсэн, шатахуун, нефтийн бүтээгдэхүүний төлбөр тооцоо саатаж цаашлаад Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл бий болоод байгаа тул ОХУ-ын төв банктай шууд хамтран ажиллах, СПФС системд банкуудыг холбох ажлыг эхлүүлэх шаардлагатай байгаа тухай, мөн ОХУ-ын банкуудтай манай дотоодын арилжааны банкууд хамтран ажиллах хүсэлтийг ГХЯ-нд хүргүүлсэн.

**2022.06.13**

• Нөхцөл байдлаас шалтгаалан ОХУ-аас импортлодог шатахуун, нефтийн бүтээгдэхүүний төлбөр тооцоо саатах эрсдэл үүсээд байгаа тул ОХУ-ын нэр бүхий банкуудтай холбогдож дотоодын банкуудтай хамтран ажиллах талаар дэмжлэг үзүүлэхийг хүсэлтийг ОХУ-ын Элчин сайдын яаманд хүргүүлсэн.

**2022.06.17**

• Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газарт үүсээд буй нөхцөл байдал болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар албан захидал хүргүүлсэн



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Анхаарал хандуулсанд баярлалаа!

---